ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭ-ОЧИРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 85.6 | 59.9 |

**1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Хариуцсан чиг үүргийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдах | 100 | 15.0 |
| 2. | Удирдлагын манлайлал чиглэлээр сургалтад хамрагдах | 100 | 15.0 |
| 3. | Үндэсний бичгийн мэдлэг чадвараа сайжруулах, компьютерын цэс суулгаж албан хэрэгцээндээ ашиглаж хэвших | 70 | 14.0 |
| **Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 14.7 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14.0 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 14.0 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15.0 |
| 4. | Манлайлах | 15.0 |
| 5. | Багаар ажиллах | 14.0 |
| 6. | Харилцаа | 14.0 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 14.3 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт )* | 59.9 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.7 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 14.3 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | — |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *( Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих )* | — |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 88.9 |

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ............................ /Ш.ЭРДЭНЭБАТ/

)

2025 оны 12 сарын 09 өдөр

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***нэгжийн дарга:***

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............................ /Н.ЭРДЭНЭ-ОЧИР/

2025 оны 12 сарын 09 өдөр

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт--гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **ЗОРИЛТ 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | | |
| 1 | Зорилт 1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1.1 | Арга хэмжээ 1.1. Хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулах, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэхэд иргэд, төрийн албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох сургалт сурталчилгааг зохион байгуулна. | - | Хамрагдсан хүний тоо | 1000 | 1000-аас доошгүй | 1200-аас доошгүй | Аймгийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/474 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын дэргэд “Хүний эрх хамгаалах зөвлөлийг” 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан чиг үүргийн дагуу ажиллаж байна.<br>Мөн 18 сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд “Хүний эрх хамгаалах” зөвлөлийг байгуулан хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн<br>“Хүний эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцооны тухай ойлголт” сэдвийн хүрээнд 15 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 1,817 иргэнд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. | |
| 1.2 | Арга хэмжээ №1.2. Эрх зүйн хөтөч нарыг мэргэшил, арга зүйгээр хангаж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Зөвлөмж, мэдээллээр хангасан хүний | 5000 хүнд сургалт зохион байгуулсан байна | 5000-аас доошгүй | 5500-аас доошгүй | Монгол Улсын Их Хурлаас 2025 онд шинээр баталсан хуулиудын системчлэлийг хийж сумдын, эрх зүйн хөтөч нарт хүргүүлсэн бөгөөд тус хуулиудыг сурталчлах иргэд, байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулж ажиллахыг даалгасан.<br>Аймгийн хэмжээнд нийт 79 эрх зүйн хөтөч чиг үүргийн дагуу ажиллаж, 4,150 хүнд хууль сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.<br>Мөн аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байгуулсан эрх зүйн хөтчийн булангийн мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн ажиллаж байна. | 90 |
| 1.3 | Арга хэмжээ №1.3. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, батлан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдөх | - | Шинээр бүртгүүлсэн хэм хэмжээний актын тоо | 29 | 15-аас доошгүй | 20-иос доошгүй | Захиргааны ерөнхий хууль, холбогдох журмын шаардлага хангасан эсэхийг хянан үзээд:<br>Бугат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 12 дугаар "Малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай" тогтоол,<br>Шарга сумын иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 10 дугаартай "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" тогтоол,<br>Дэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 17 дугаартай "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоол,<br>Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн 08 дугаартай "Хог хаягдлын үйлчилгээний хураамж нэгжийн үнэ тариф батлах тухай"<br>Бигэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 26-ний 02 дугаартай "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" тогтоол,<br>Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний 21 дугаартай Гол мөрний урсац, бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай тогтоол,<br>Хөхморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 07-ний 03 дугаартай Гол мөрний урсац, бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай тогтоолуудыг хуульд заагдсан бүрдлийн шаардлагыг хангаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлvбөгөөд Улсын нэгдсэн санд бүртгэлтэй нийт 40 захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. | |
| 1.4 | Арга хэмжээ №1.4. Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн | - | Хэрэгжилтийг хангасан ажлын тоо | - | Өөрт хамаарах ажлын 2025 оны | Өөрт хамаарах ажлын 2025 оны | Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу "Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого", | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлийн дагуу "Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангах | | | | хэрэгжилтийг хангах | хэрэгжилтийг хангах | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үзэл баримтлалыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Тус аймаг нь хүний хөгжлийг тэргүүнд тавьж боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, аялал жуулчлалын ажлыг эрчимжүүлж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлж иргэнд ээлтэй амьдрах орчныг бүрдүүлэх зорилготой ажиллаж байна. | |
| 1.5 | Арга хэмжээ №1.5. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хэрэгжилтийг хангасан ажлын тоо | - | Өөрт хамаарах ажлын 2025 оны хэрэгжилтийг хангах | Өөрт хамаарах ажлын 2025 оны хэрэгжилтийг хангах | Аймгийн хэмжээнд хүний эрхийг хангах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомж, шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/474 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын дэргэд "Хүний эрх хамгаалах зөвлөл-ийг" 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан чиг үүргийн дагуу ажиллаж байгаа бөгөөд тус аймгийн 18 сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд 7-9 бүрэлдэхүүнтэй "Хүний эрх хамгаалах" зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.<br>Аймгийн Засаг даргын санаачилгаар хүн амын дундаж наслалтыг 80-аас дээш хүргэх зорилт бүхий "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжүүлж 12 төрлийн үзлэг, оношилгоо бүхий явуулын эмнэлгийн үйлчилгээг алслагдсан баг, сумын төвийн иргэдэд хүргэж ажиллалаа.<br>Орон нутгийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах, хангахын тулд Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан аймгийн бодлого төлөвлөлтийг статистик, дүн шинжилгээ, судалгаанд тулгуурлан жендерийн тэгш оролцоотой байх бүх насны иргэд үр нөлөөг нь тэгш шударга хүртэх байдлаар аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус боловсруулж батлуулан, хэрэгжүүлж байна.<br>Тус хөтөлбөрт тусгайлан хүний эрхийг хангах тогтолцоог бүрдүүлэх зорилго, зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэхэд тогтвортой, оновчтой, үр өгөөжтэй хөрөнгө оруулалт, бүх түвшний түншлэл хамтын ажиллагааг чухалчлан төрийн хариуцлагыг сайжруулахад анхааран ажиллаж байгаа бөгөөд сумдын бодлого, шийдвэрт мөн адил баримталж байна.<br>МУЗГ-ын 357 дугаар тогтоолоор баталсан НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого чиглэлийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс зохион байгуулж буй эрүүл мэндийн үзлэг оношилгоонд аймгийн хуулийн байгууллагын албан хаагчид сумын хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтнүүд нийт 600 албан хаагчийг хамруулж ажиллалаа. | |
| 1.6 | Арга хэмжээ №1.6. Мал хулгайлах, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | - | Буурсан хувь | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт, мал хулгайлах гэмт хэрэг, нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт,согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх жин, хувь буурсан байна. | Тус бүр 1 хувиар бууруулна. | Тус бүр 1 хувиар бууруулна. | Тайлант хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлд заасан “мал хулгайлах” гэмт хэргийн шинжтэй нийт 2 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан. Бүртгэгдэн шалгагдсан 2 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.<br>Энэ онд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгагдсан 2 хэргийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг олж тогтоосон бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах чиглэлээр мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.<br>Мөн урьд онуудад үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байгаа мал хулгайлах 21 хэрэг бүртгэлтийн хэргүүдэд мэдээ, мэдээлэл цуглуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Мал хулгайлах гэмт хэрэг эхний 5 сарын байдлаар | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2 бүртгэгдэж урьд оны мөн үеэс 3 хэргээр буюу 60 хувиар буурсан байна. | |
| 1.7 | Арга хэмжээ №1.7. Аймаг, сумдын төвийн гэр хорооллын хяналтын камертай гудамжны тоог нэмэгдүүлэх, хяналтын камерын нэгдсэн төвтэй болох | - | Нэмэгдүүлсэн хяналтын камертай гудамжны тоо, | 150 | 200-оос доошгүй | 250-аас доошгүй | Тус ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 162, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчинд суурилуулсан 28 камер, Дэлгэр, Баян-Уул, Төгрөг, Алтай, Тонхил, Хөхморьт, Цогт сумдыг дэд төвтэй холбох зэрэг 7 сумын камержуулалтыг дэд төвд холбосон.<br>Мөн Говь-Алтай-Баянхонгор чиглэлийн улсын чанартай замд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дугаар таних камер 2 ширхгийг байршуулан үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Улсын хэмжээнд теле хяналтын нэгдсэн систем байгуулах ажлын хүрээнд “Дэд төв”-ийн үйл ажиллагаанд ашиглахаар сонгосон ухаалаг программ хангамж “IREX”, видео удирдлагын нэгдсэн систем “NX WITNESS”-ийг албан ёсны лицензтэй нэвтрүүлэх зорилгоор төсвийн тооцооллыг гаргаж албан бичгээр Хан Алтай ресурс ХХК-д хүргүүлж, төлөөлөн удирдах зөвлөлөөр 203 сая төгрөгийг шийдүүлэн “Спийд аксон” ХХКомпани тендэрт шалгарч тоног төхөөрөмжийн лицензийн худалдан авалтыг хийн, 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 70 лиценз, “IREX ухаалаг программ хангамжийг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суурилуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.<br>Тус аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 217 камер, аж ахуйн нэгж байгууллагын гадна орчинд суурилуулсан 770 камерыг http://camera.police.gov/ санд бүртгэсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 162, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчинд суурилуулсан 28 камер, 3 сумын камержуулалтыг дэд төвд холбосон.<br>Мөн Говь-Алтай-Баянхонгор чиглэлийн улсын чанартай замд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дугаар таних камер 2 ширхгийг байршуулан үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Энэ оны эхний 12 сарын байдлаар 10 камерыг "Дэд төв"-д холбосон. | |
| 1.8 | Арга хэмжээ №1.8. Төрийн архивын барилгыг ашиглалтад орсонтой холбогдуулан тус байгууллагад ашиглагдах тоног төхөөрөмжийг шинэчлэн нэмэгдүүлнэ | - | Тухай бүр | Шаардлагатай хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх, тоног төхөөрөмжийг шинэчилсэн тоо | Архивын цаасан суурьтай баримт, тусгай төрлийн, цахим баримт хадгалах зориулалтын тавиур шүүгээ байхгүй, сандал ширээ, компютер, принтер, скайнер, | Архивын хадгалалт хамгаалалт сайжирч, шаардлагатай хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Төрийн байгууллагуудын архивын хөмрөгийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цаасан суурьтай баримтаас цахим архивын баримтыг үүсгэх, архивын үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын захирамжаар үе шаттай шийдвэрлүүлж байна.<br>Энэ онд суурин компьютер-3ш, А3 сканнер-1ш, А4 сканнер- | 100%.<br>50<br>+ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бусад шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж дутагдалтай. | | 1ш, өнгөт принтер-1ш тус тус шийдвэрлэлээ. Нийт 20.0 сая шахам төгрөгийн тоног төхөөрөмж, пос машин авч өгсөн | |
| 1.9 | Арга хэмжээ №1.9. Төрийн архивын улсын үзлэг 2025 онд зохион байгуулагдахтай холбогдуулан урьдчилсан хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг байгууллагуудад зохион байгуулах | - | Байгууллагын тоо | 100 | 120 | 150 | Улсын үзлэг зохион байгуулагдахтай холбогдуулан 160 төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдад заавар, зөвлөгөө өгч бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын үзлэг зохион байгуулах тухай удирдамж, шалгуур үзүүлэлт, хугацаа товлогддог тул зохион байгуулалтын ажил хүлээгдэж байна. | 50 |
| 1.10 | Арга хэмжээ №1.10. Хууль эрх зүйн сургалт сурталчилгааг аймгийн хэмжээнд зохион байгуулна. | - | Хамрагдсан хүний тоо, зохион байгуулсан сургалтын тоо | 10-аас доошгүй сургалт зохион байгуулж, 5000-аас доошгүй хүнд сургалт сурталчилгаа хийсэн байна. | 5-аас доошгүй сургалт зохион байгуулж, 2500-аас доошгүй хүнд сургалт сурталчилгаа хийсэн байна. | 5-аас доошгүй сургалт зохион байгуулж 2500-аас доошгүй хүнд сургалт сурталчилгаа хийсэн байна. | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийг сурталчлах, иргэд олон нийтийг эрэлт хэрэгцээт шаардлагатай мэдээллээр хангах, тэдний хууль зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Алтай мэдээ агентлаг, Алтай мэдээ радиогоор Монгол Улсын Их Хурлаас баталсан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 12 хуулиар мэдээлэл бэлтгэж яриа өгсөн бөгөөд 5,000 иргэнд хүрч иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ. Мөн Авлигын эсрэг уриалсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | видео контентыг бүтээж Миний Алтай сошиал ТВ, Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, Сүбээдэй.МН сайт, UBS телевизээр иргэдэд түгээн 8,000 иргэний хандалт авсан байна.<br>Тус ажлын хүрээнд аймаг сумын төрийн байгууллагууд нийт 32 байгууллага авлигын эсрэг аянд нэгдэж авлигын эсрэг уриалсан 32 видео контентыг бүтээж боломжит эх үүсвэр цахим хаягуудаар иргэдэд түгээн ажилласан.<br>Шинээр батлагдсан хуулиудыг сурталчлах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, хуульчийн группээр нийтэлж иргэдэд түгээж ажиллалаа.<br>2025 онд дагаж мөрдөх шинээр батлагдсан хууль тогтоомжууд болон “Төрийн болон албаны нууцын тухай”, “Төрийн болон албаны нууц хамгаалах журам”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцооны тухай ойлголт”, “Хүүхэд хэрэглэгч”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Үндэсний аюулгүй байдлын тухай” “Авлигын эсрэг хууль”, “Төрийн албаны тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”, “Зөрчлийн тухай”, “Эрүүгийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай", "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай"," Цахим гарын үсгийн тухай тухай хууль", "Хүний эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцооны тухай ойлголт","Хуульчийн Про боно" өдөрлөг зэрэг арга хэмжээний хүрээнд 15 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, аймаг, сумын хэмжээнд давхардсан тоогоор 7,300 иргэнд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.<br>Мөн аймгийн хэмжээнд Хууль тогтоомжийг сурталчлах 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| **ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | | |
| 2 | Зорилт 2. Хуулийн хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 2.1 | Арга хэмжээ №2.1. Хууль зүй, дотоод хэргийн сайд аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангана. | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | 95.6 | 90-ээс доошгүй | 93-аас доошгүй | Хууль зүй, дотоод хэргийн сайд аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний 20 заалт, хавсралтаар баталсан 16 арга хэмжээг хяналтад авч, картлан харьяа агентлагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган хагас жилийн байдлаар гэрээний заалтыг 85 хувь, хавсралтаар баталсан арга хэмжээг 87.5 хувьтай хэрэгжүүлэн, биелэлтийг заасан хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамд тайлагнасан. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Арга хэмжээ №2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | Гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан байна. | - | 90-ээс доошгүй | 95-аас доошгүй | Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Уусан бол бүү жолоод”, “Аюултай ачаа”, “Улсын дугаар”, “Гэрэлтүүлэг”, “Сар шинэ-2025”, “Хуулиа мөрдье”, “Цахим архи”, “Акц”, “Хамгаалах малгай”, “Сигнал”, “Байгалиа хамгаалъя”, “Залилах”, “Хуулийн хэрэгжилт”, “Хяналт шалгалт”, “Мэдэгдэл”, “Шөнийн эргүүл”, “Дүрмээ мөрдье”, “Зөрчил”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Илрүүлэлт”, “Гэрэл”, “Ачаа тээвэр”, “Оюутан тээвэр”, “Хичээл эхэллээ”, “Тамхигүй ирээдүй”, “Тор”, “Шийдвэрлэлт”, “Мал мах”, “Дугуй”, “Хуулийн хэрэгжилт”, “Галт зэвсэг” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн 43 арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Тухайлбал: Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр “Хуулиа мөрдье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан, 4.000.000 сая төгрөгийн шийдүүлэн аймгийн Татварын хэлтэстэй хамтран ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Архины хамааралтай иргэн Б.Баярмааг Архины хордлогоос урьдчилан сэргийлж архины албадан эмчилгээнд явуулах зорилгоор эрүүл мэндийн дүгнэлтийг гарган холбогдох материалыг бүрдүүлэн албадан эмчилгээнд явуулахаар аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албадан эмчилгээнд явуулах шийдвэрийг гаргуулан Баянхонгор аймагт эмчилгээнд хамруулсан.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цахим залилан”, “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт-Хор уршиг”, “Архины хэрэглээ ба хор уршиг”, “Эцэг, эх, асран хамгаалагчийг үүрэг, хариуцлага”, “Хүүхдийн эрхийн тухай ойлголт”, “Гэмт хэргийн тухай ойлголт-Хор уршиг”, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт”, “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал” зэрэг сэдвээр 184 аж ахуйн нэгж, байгууллагад, 21635 иргэнд сургалт, ухуулга яриа хийж, зам тээврийн осол, хэрэг, хулгайлах, залилах, архи согтууруулах ундааны хэрэглээ зэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 64 мэдээ, мэдээллийг бэлтгэн 65152 ширхгийг тараан ажиллалаа.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудаст жагсаал цуглаан, залилах, зам тээврийн осол, хэрэг, галт зэвсгийн эзэмшигч нарт, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, экологийн болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн нийт 2125 мэдээ, мэдээллийг байршуулан 151610 хандалт авсан. Тус газраас аймгийн тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 45 видео, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 118 постер нийт 163 видео, рийл, постерыг бэлтгэн цахим орчинд байршуулсан түгээлт хийн, иргэд олон нийтэд хүргэж ажилласан.<br>Аймгийн "Алтай" радиогоор 9 удаа, орон нутгийн "Миний нутаг", "Алтай" телевизүүдээр 18 удаа мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан.<br>2025 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 343 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 9 нэгжээр буюу 2.7 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 63.3 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 2.9 функтээр өссөн. | |
| 2.3 | Арга хэмжээ №2.3 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90-ээс доошгүй | 95-аас доошгүй | Цагдаагийн газрын тусгай дугаарын утсанд давтамжтай дуудлага, мэдээлэл энэ оны эхний 10 сарын байдлаар 3 бүртгэгдэж, хариуцсан багийн Засаг дарга, Хамтарсан багт мэдэгдэл хүргүүлэн, биелэлтийг тооцож ажилласан.<br>Архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг. Бага насны 5 хүүхэдтэй иргэн, архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг. Сургуулийн насны 1 хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай ээжтэй иргэн. 2 иргэнийг архины албадан эмчилгээнд явуулсан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл шүүхийн шатан дээр зүйлчлэл өөрчлөгдөж байгаатай холбогдуулан эргүүлийн, болон дуудлага мэдээлэл хүлээн авч | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цагдаа нарт энгэрийн камерыг зөв хэрэглэх, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл дээр ажиллахдаа аюулын зэргийн үнэлгээг энгэрийн камертай хийх, энгэрийн камерын бичлэгийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар оруулах чиглэлээр алба хаагчдад 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01 дугаартай зөвлөмж хүргүүлж ажилласан. Мөн гэр бүлийн хүчирхийллийг өөр зүйл заалтаар төсөөтэй шийдвэрлэж байгаатай холбоотой нотлох баримт бүрдүүлэх зорилгоор 100 ширхэг CD-ний төсвийг Есөнбулаг сумаас шийдүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар ашиглаж байна.<br>Тус аймгийн Есөнбулаг сумын Оргил багийн засаг даргад тус багт оршин суух гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэнд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хариуг ирүүлэх талаар 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 35/4823 албан бичиг хүргүүлж, ажил, арга хэмжээний үр дүнг тооцон ажилласан.<br>Шарга сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр “Бидний Өнөөдөр-Хүүхдийн ирээдүй” өдөрлөгийг зохион байгуулан 170 иргэнд “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь", "Үе тэнгийн дээрэлхэлт", "Замын тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдээр сургалт мэдээлэл хийж, 4 төрлийн санамж, зөвлөмж, сэрэмжлүүлгийг бэлтгэн 390 ширхгийг тараан ажиллалаа.<br>"Хүчирхийлэл давтагдах ёсгүй" арга хэмжээний 432000 мянган төгрөгийн төсвийг Есөнбулаг сумаас шийдүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран зохион байгуулж, нуугдмалаар үйлдэгдэж байгаа гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгддэг 20 өрхийн 20 хохирогч, 20 холбогдогч нарын судалгааг гаргасан. Судалгаанд үндэслэн 20 айл өрхөөр орж хяналт шалгалтыг хийж, ахуйн хэрэглээний багцыг 5 өрхөд, эмзэг бүлгийн 5 өрхийн хүүхдүүдэд ахуйн хэрэглээний багц, 1 өрхөд дулаан хувцасны багцыг тус тус өгч ажилласан. Эрсдэлт нөхцөл байгаа 20 хүүхдийн судалгаа, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг эмзэг цэгийн судалгаануудыг тус тус гаргасан.<br>Мөн "Хөршийн холбоо" сэргээж 3 төрлийн санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэн гарган 80 ширхгийг тарааж, 10 багт "ЗОГС" нэртэй баннер тавьж ажилласан. "Өөрийгөө өөрчилье" нөлөөллийн арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний 3.468.000 мянган төгрөгийн төсвийг Есөнбулаг сумаас шийдүүлж. 2025 оны 11 дүгээр сарын 27-30-ны өдөр зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 19 бүртгэгдсэн урьд оны мөн үеэс 12 нэгжээр буюу 2.7 дахин өссөн. | |
| 2.4 | Арга хэмжээ №2.4. Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг болон хүүхэд холбогддог гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжиж ажиллах | - | Хүүхдийн эсрэг үйлдсэн болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох судалгаа хийж, дүнг ГХУСАЗСЗ-д танилцуулсан байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор дамжуулан эрх, хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн хамгийн багадаа 50 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. | Хүүхдийн эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг болон хүүхдээс үйлдэгддэг гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг бодитойгоор дэмжиж үр дүнд хүрсэн байна. | 90-ээс доошгүй | 95-аас доошгүй | Насанд хүрээгүй хүнээс гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хуралдуулж цаашид хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн төлөвлөгөө гарган насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/178 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гарч уг захирамжийн хүрээнд ажлыг хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хуралдаж цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, “Хамтын шийдэл-хамгаалагдсан ирээдүй” хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийг боловсруулан батлуулан, хөтөлбөрийн хүрээнд ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд хамгаалал”, “Хичээл эхэллээ”, “365 анхаарч хайрлая”, “Хүн бүр хүүхэд хамгаалагч”, “Мэдээлье нөлөөлье”, “Бидний хүүхэд-Бидний ирээдүй”, “Өсвөрийн сэргийлэгч-2025”, “Замын хөдөлгөөний цагаан толгой-2025”, “Автомашингүй өдөр” зэрэг нөлөөллийн болон нэгдсэн хэсэгчилсэн арга хэмжээ, тэмцээн уралдааны зохион байгуулан ажиллалаа.<br>Зохион байгуулсан ажил арга хэмжээний хүрээнд “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт-Хор уршиг”, “Архины хэрэглээ ба хор уршиг”, “Эцэг, эх, асран хамгаалагчийг үүрэг, хариуцлага”, “Хүүхдийн эрхийн тухай ойлголт”, “Гэмт хэргийн тухай ойлголт-Хор уршиг”, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт”, “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал”, “Электрон тамхины хор уршиг”, “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвүүдээр 6255 сурагч, эцэг, эх асран хамгаалагчид сургалт, мэдээлэл хийж, 10 төрлийн хууль, эрх зүйн гарын авлага, зөвлөмж 8635 ширхгийг тараасан.<br>Тайлангийн хугацаанд түр хамгаалах байраар 32 хүн үйлчлүүлснээс насанд хүрсэн 7 эмэгтэй, насанд хүрээгүй хохирогч хүүхэд 25 үйлчлүүлсэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. | |
| 2.5 | Арга хэмжээ №2.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажилд бүх талаар дэмжлэг үзүүлэх | - | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл | 90-ээс доошгүй | - | Энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна. | Тус газраас "Анзаар-2" арга хэмжээний хүрээнд Урьдчилан сэргийлэх алба болон Хар тамхитай тэмцэх газраас бэлтгэсэн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, илрүүлэх техник хэрэгслийг ашиглах", "Хорт зуршил ба донтолт", өсвөр насны хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бусдын ятгалгад автан мансууруулах бодис хэрэглэхгүй байх, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллээр бэлтгэгдсэн 18 постер, 37 рийл, видео, 1 ТВ-ээр бэлтгэгдсэн мэдээллийг Цагдаагийн газрын пэйж хуудсанд байршуулан 86.312 хандалтыг авсан байна.<br>"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүн илрэх шинж тэмдэг, хууль зүйн хариуцлага, өөрийгөө болон бусдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх нь", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, илрүүлэх техник хэрэгслийг ашиглах нь" зэрэг сэдвийн хүрээнд 2 байгууллагын 130 алба хаагчид, 5 сургуулийн 635 багш, асран хамгаалагчид сургалт, мэдээллийг өгч ажиллалаа.<br>Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэдэг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчтөнүүдийг тоон судалгааг гарган, эмийн сангийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт, шалгалтыг 1 удаа хийсэн. Хяналт шалгалтаар 2025 эхний 8 сарын байдлаар 692 иргэн сэтгэцийн эмчийн хяналтад байдгаас 403 иргэн групп тогтоолгосон.<br>Өвчний улмаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг 2 төрлөөр эмчлүүлэгчдэд олгодог бөгөөд гадуур жороор 54, эмнэлгээс 19 иргэнд эм олгосон байна.<br>Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.<br>“Тамхигүй ирээдүй” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 24 ерөнхий боловсролын сургуулийн 860 сурагчдад “Электрон тамхинаас үүдэлтэй дам тамхидалт”, “Хорт зуршил”, “Тамхины хор хөнөөл” сэдвүүдээр сургалт мэдээлэл хийж зөвлөмж, тараах материал тарааж ажиллалаа. хариуцсан нутаг дэвсгэрт Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 20:00-22:00 цагийн хооронд 7 чиглэлд 14 алба хаагчид үүрэг гүйцэтгэн ажиллаж 72 хүнсний дэлгүүрийн зарын самбарт зурагт хуудсыг байршуулж үйл ажиллагаанд нь хяналт шалгалт зохион | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулан, Зөвшөөрөлгүй утаат тамхи худалдсан 1 зөрчил илрүүлэн, 5 аж ахуйн нэгжид 5 мэдэгдэл хүргүүлэн ажиллалаа. | |
| 2.6 | Арга хэмжээ №2.6. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах | - | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл | 90-ээс доошгүй | - | Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | Цагдаагийн байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн яамны Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний дагуу тус Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 02 дугаар тогтоолоор шинэчлэгдэн байгуулагдсан хууль хяналтын байгууллагуудаас бүрдсэн “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл” хуралдаж сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 3 бүлэг 14 заалттай боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, бөгөөд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн дарга Л.Насанбуян 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр арга хэмжээг зохион | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж ажиллав.<br>Дэд зөвлөлтэй хамтран 3-н төрлийн постер, видео контент 1, аймгаас дамжин өнгөрөх зам дагуу 3 ширхэг самбар зэргийг “Байгалиа хамгаалъя”, “Эко-2025” арга хэмжээний уриалга фрэйм логоог иргэд олон нийтэд танилцуулах сурталчилж, 135 алба хаагчдын цахим хуудсанд коверыг солиулж байгалиа хамгаалъя urианд нэгдүүлсэн.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.1-д заасны дагуу хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр Цагдаагийн газраас Есөнбулаг сумын Засаг дарга, Байгаль орчны газрын дарга нарт 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр бүлэг бөөгнөрөл үүсэж болзошгүй газруудад урьдчилан сэргийлэх таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллах 35/2108 дугаартай хугацаатай албан бичиг хүргүүлсэн.<br>Хууль бусаар газрын хэвлийд халдах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Тонхил, Дарви, Алтай, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумдын засаг дарга нарт мэдэгдэл, шаардлага, зөвлөмжийг хүргүүлэн, биелэлт үр дүнг тооцон ажилласан. Тус газраас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэмцэх чиглэлээр Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын дунд 2025 онд зохион байгуулсан мэргэшүүлсэн сургалтын төлөвлөгөөний дагуу Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа сэдэвт сургалтад 2025 оны 06 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд цахимаар 1 алба хаагч оролцсон.<br>Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Тайшир сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөлийн дарга нарт зөвлөмж хүргүүлж хэсгийн төлөөлөгч цагдаа, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулан иргэд олон нийттэй хамтран мэдээ мэдээлэл солилцон ажиллаж байна.<br>Тайлангийн хугацаанд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 22 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 21 хэргээр буюу 22 дахин өссөн үзүүлэлттэй байна. | |
| 2.7 | Арга хэмжээ №2.7. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг | - | Хамтран хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл | 90-ээс доошгүй | - | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн | Тус цагдаагийн газраас гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, давтамжтай дуудлага, мэдээллийг бууруулах, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулах чиглэлээр “Цахим архи”, “Хуулийн хэрэгжилт”, “Хуулиа мөрдье” | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | | | | | хэрэгжилтийг хангаж ажилласан байна | зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.<br>Тухайлбал: "Цахим архи худалдаа" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 14-с 2025 оны 03 дугаар сарын 14 хүртэл зохион байгуулан ажиллаж Гар дээрээс согтууруулах ундаа худалдсан 2 иргэнээс Бигэр дарс 14 ширхэг 10.5 лирт, Бигэр Виски 3 ширхгийг хураан авч, 2 иргэнийг 1.000.000 төгрөгөөр торгож, хугацаа дууссан 1 зөрчил, акцын зөрчилтэй 1 зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлсэн.<br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг нөхцөлд байдалд дүн шинжилгээг хийж, бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд 2024, 2025 оны эхний 05 сард согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг өөрчлүүлэх саналыг аймгийн Засаг даргад 2025 оны 2 сар, 2025 оны 4 сар, 2025 оны 10 дугаар саруудад 3 удаагийн албан бичгүүдийг хүргүүлэн ажилласан.<br>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж иргэн, хуулийн этгээдийн судалгаанд үндэслэн эрх бүхий этгээдэд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор 54 мэдэгдэл, 16 шаардлагыг хүргүүлж, 57 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдэгдэл, шаардлагын хариуг хугацаанд нь авч, биелэлт үр дүнг тооцож ажиллаллаа.<br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр 35 төрийн байгууллага, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 196 аж ахуйн нэгж байгууллагын нийт 6250 иргэнд "Архи согтууруулах ундааны хор уршиг", "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн ойлголт", "Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт", аймгийн Мэргэжлийн сургуулийн 150 сурагч, АШУҮИ Сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар сургуулийн 900 оюутанд "Архи ба хүүхэд", "Өсвөр үеийнхний дундах согтууруулах ундааны хэрэглээ, хор хөнөөлийн талаар" сэдэвт сургалтуудыг Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Д.Сугартай хамтран зохион байгуулж, 8030 ширхэг гарын авлага, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тараан, 325 байгууллага, аж ахуйн мэдээллийн самбарт согтууруулах ундааны талаарх бэлтгэгдсэн гарын авлагыг QR болгон байршуулан ажиллалаа.<br>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар бэлтгэсэн 41, хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр бэлтгэсэн 12, гэр бүл, хүүхдийн чиглэлээрх 25 видео, штрок, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | постерыг цагдаагийн газрын пэйжид байршуулан түгээлт хийж, аймгийн төв талбайд байрлах лед дэлгэцээр 3 видеог байршуулж алба хаагчдаар түгээлт хийлгэн, хүн ихээр цуглардаг "Шинэ-Алтай" захын узелээр аудио бичлэгүүдийг өдөрт 3 удаагийн давтамжтайгаар явуулж иргэдэд хүргэж ажиллалаа.<br>Аймгийн Алтай радио 1 удаа мэдээлэл хийж, өндөр хандалттай Алтай мэдээ агентлагийн фэйж хаягаар 3 видеог байршуулан иргэдэд түгээж ажиллалаа.<br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 161 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 50 хэргээр буюу 45 хувиар өссөн байна. | |
